



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/110

Мөрөн сум

Газар эзэмших эрхийг дуусгавар болгож,  
өмчлүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дүгээр зүйлийн 60.1.1, 66 дүгээр зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 7 дугаар зүйлийн 7.1, 12 дугаар зүйлийн 12.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны Х хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын өргөн мэдүүлснээр нэр бүхий иргэдийн гаргасан өргөдлийг үндэслэн энэхүү захирамжийн нэгдүгээр хавсралтад заасан 3 иргэний газар эзэмших эрхийг 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөр тасалбар болгон дуусгавар болгож, мөн өдрөөс эхлэн тус иргэдэд нийт 1979м<sup>2</sup> газрыг энэ захирамжийн хоёрдугаар хавсралтад заасны дагуу гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлсүгэй.

2. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газраа өмчилж авахаар шийдвэр гаргуулсан иргэдийн газрыг улсын бүртгэлд бүртгэж, баталгаажуулахыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т даалгасугай.


3. Хувийн хэргийн бүрдүүлэлтийг ханган, өмчилсөн газрыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, мэдээллийн санд оруулж, захиргааны актыг оролцогчдод мэдэгдэхийг аймгийн Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү шийдвэрийг оролцогчид эс зөвшөөрвөл мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5. Газар өмчлөгчийн үүргийн биелэлтэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Мөрөн сумын Засаг дарга (Д.Идэрмөнх)-д даалгасугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (М.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

6717010447



Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 20-ны  
өдрийн А/10 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

ГЭР БҮЛИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ЗОРИУЛАЛТААР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ЗАХИРАМЖИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ЖАГСААЛТ

№	Ургийн овог	Эцэг эхийн нэр	Өөрийн нэр	Регистрийн дугаар	Зориулалт	Газрын байршил /хаяг/	Газрын хэмжээ /м2/	Нэгж талбарын дугаар	Эзэмших эрхийн	
									Огноо дугаар	Хавсралтын дугаар
1	Их хотхон	Дашлхүмбэ	Даваадорж	РС96040135	Гэр, орон сууцны хашааны газар	7.13.10	736	6712016650	2021.05.27 А/279	6 дугаар заалт
2	Бичээч	Цэрэндорж	Сарангэрэл	ЦЖ69050502	Гэр, орон сууцны хашааны газар	4.12.18	777	6712000227	2022.11.11 А/194	4 дугаар заалт
3	Байчууд	Бямбахүү	Сосорбарам	РЭ97022101	Гэр, орон сууцны хашааны газар	4.6.12	466	6712000189	2023.01.25 А/12	7 дугаар заалт
								1979		



Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 21-ны  
өдрийн А/10 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

ГЭР БҮЛИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ЗОРИУЛАЛТААР ГАЗАР ӨМЧЛӨГЧ ИРГЭДИЙН ЖАГСААЛТ

№	Ургийн овог	Эцэг эхийн нэр	Өөрийн нэр	Регистрийн дугаар	Зориулалт	Газрын байршил /хаяг/	Газрын хэмжээ	Газрын үнэ	Нэгж тапбарын дугаар
1	Их хотхон	Дашлхүмбэ	Даваадорж	РС96040135	Гэр, орон сууцны хашааны газар	7.13.10	736	2208.0	6712016650
2	Бичээч	Цэрэндорж	Сарангэрэл	ЦЖ69050502	Гэр, орон сууцны хашааны газар	4.12.18	777	2331.0	6712000227
3	Байчууд	Бямбахүү	Сосорбарам	РЭ97022101	Гэр, орон сууцны хашааны газар	4.6.12	466	1398.0	6712000189
							1979		

